



Ашигт малтмалын засаглалын индекс (АМЗИ) нь 58 улсын газрын тос, байгалийн хий, олборлох салбарын засаглалын чанарыг үнэлдэг болно. **Нэмэлт мэдээллийг www.revenuewatch.org/rqi сайтаас авна уу.**

Суурь мэдээлэл

Монгол улсад ихээхэн хэмжээний зэс, алт, нүүрс, молибден, жонш, уран, цагаан тугалга болон вольфрамын ашигт малтмалын нөөц байгаа болно. 2010 онд ашигт малтмалын салбар ДНБ-ын 46 хувь, 2007 онд экспортын 80 хувийг тус тус бүрдүүлж байсан. Хятад болон өөр бусад хөрш улсууд руу ашигт малтмалын экспорт нэмэгдсэнээс ихэвчлэн шалтгаалж, 2011 онд Монгол улсын эдийн засаг 18 хувиар өссөн.

Монгол улс	2000	2005	2011
Хүн ам (сая)	2.41	2.55	2.80
ДНБ (2011 Оны тогтмол дүнгээр, олон улсын, тэрбум ам.доллараар)	1.5	2.9	8.8
Нэг хүнд ноогдох ДНБ, (2011 Оны тогтмол дүнгээр, олон улсын, тэрбум ам.доллараар)	2,208	2,862	4,187
Олборлох аж үйлдвэрлэлийн салбарын экспорт (нийт экспортын хувиар)	42%	63%	80%

Эх үүсвэр: Дэлхийн Банк. Олборлох салбарын тайлан мэдээлэл. 2007 оноос 2011 оны өгөгдөл тайлан.

Монгол улсын Ашигт малтмалын засаглалын индекс дахь үзүүлэлт

Монгол улс 58 улсаас “бүрэн бус” буюу 51 оноо авч, 26-р байранд орсон. Монгол улс бүтэц болон хууль эрх зүйн зохицуулалтаар маш сайн оноо авсан ч, мэдээлж, тайлагнах чиглэлээр муу оноо авсан болно.


Бүтэц болон хууль эрхзүйн зохицуулалт (Зэрэглэл: 9-р байр/58 оноо: 80/100)

Монгол улс “хангалттай” оноо буюу 80 оноо авсан нь орлогыг цуглуулах тодорхой арга механизм байгаа боловч, бодит байдал дээр тэр бүр хэрэгждэггүй тайлагнаж, мэдээлэхэд тавигддаг олон шаардлагуудыг тусган харуулж байна.

Монгол улсын Ашигт малтмалын газар ашигт малтмалын салбарыг зохицуулж, эхэлж, түрүүлсэнд нь тусгай зөвшөөрлийг олгож, роялти, татвар оногдуулдаг. Тус газар нь төрийн мэдлийн компани болон Эрдэнэс МГЛ-ээс хамааралгүй, бие даан ажилладаг. Сангийн яам уул уурхайн компаниудаас төлбөрийг хураан авч, ашигт малтмалтай холбоотой бүх орлогыг улсын санд төвлөрүүлдэг.

Хуулиар, ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг олгохоос өмнө, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх ёстой байдаг. Монгол улс 2011 онд Хэвлэл, Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталсан боловч, бизнесийн болон төрийн байгууллагууд зарим мэдээллээ нууцлах боломжтой хэвээр байгаа билээ. Монгол улс нь 2010 оноос хойш Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дагаж мөрдөгч орон болсон.

Тайлагнаж мэдээлэх байдал (Зэрэглэл: 41/58 оноо: 39/100)
Дотоодын уул уурхайн компанийн талаар төр засаг мэдээлэл багатай байсан тул Монгол улс ” муу ”үзүүлэлт буюу 39 оноо авсан.



Уул уурхайн тусгай зөвшөөрлийг өгөх үйл явцыг зохицуулсан хууль журам амархан хүртээмжтэй байдаг боловч, тусгай зөвшөөрлөөр олгож байгаа ашигт малтмалын ордын талаар мэдээлэл олон нийтэд бага байдаг. Ашигт малтмалын гэрээ контрактуудыг хэвлэж, нийтлэх нь ихээхэн ховор байдаг бөгөөд үйл ажиллагаа нь хэрэгжээд эхэлсэн төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан л хүртээмжтэй байдаг байна.

Сангийн яам үйлдвэрлэлийн хэмжээ, үнэ, ашигт малтмалын экспортын үнэ цэнэ, тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нэр, компаниудын үйлдвэрлэлийн өгөгдөл мэдээлэл, роялти татвар, тусгай татварууд, ноогдол ашиг, тусгай зөвшөөрлийн хураамж зэргийн талаарх мэдээллийг тогтмол хэвлэж, нийтэлдэг. Уул уурхай, Эрчим хүчний яам мөн эрэл хайгуул, боловсруулалтын чиглэлийг оролцуулсан салбарын үйл ажиллагааны мэдээллийг хэвлэдэг бөгөөд гэхдээ үүнд орлого ордоггүй байна. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар ашигт малтмалын үнэ, эрэл хайгуул, боловсруулалтын чиглэлээр хийсэн хөрөнгө оруулалтын тоо хэмжээ, тус улсад ажиллаж байгаа компаниудын нэр, роялти татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр хураамж зэргийн талаар мэдээллийг он жилийн харьцуулалтгүйгээр хэвлэж, нийтэлдэг байна. Монгол улсын 2010 оны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд орлогын задаргааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан болно.

Урьдчилан сэргийлэх болон чанарын хяналт (Зэрэглэл: 37/58 оноо: 49/100)

Монгол улс “ сул ” буюу 49 оноо авсан нь төрийн мэдлийн уул уурхайн компанид олон нийтийн хяналт сул байгааг харуулсан.

Монгол улсын Ашигт малтмалын хууль Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас тусгай зөвшөөрлийг олгох эрх мэдлийг хязгаарласан. Гуравдагч талуудад тусгай зөвшөөрлийн талаарх шийдвэрийг давж заалдахийг зөвшөөрсөн. Үндэсний аудитын газар төр засгийн төсвийг жил бүр хянаж, шалгадаг. УИХ-ын Төсвийн байнгын хороо тухайн жилд багтааж, дээрх аудитын талаар авч хэлэлцдэг болсон бөгөөд гэхдээ ашигт малтмалтай холбоотой орлогыг тусад нь авч шалгадаггүй. Саяхнаас Монгол улс ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар, ашигт малтмалын салбарыг хянах үүрэг хариуцлага хүлээсэн төр засгийн ажилтнууд олборлох салбар дахь өөрсдийн санхүүгийн эрх ашгийг ил тод болгох үүргийг хүлээсэн.

Орчныг бий болгох (Зэрэглэл: 20/58 оноо: 48/100)

Авилгалын хяналтын болон төр засгийн үр ашигтай байдлын талаарх дэлхийн түвшний үнэлгээ муу байгаагаас Монгол улс “ сул ” буюу 48 оноо авсан.

Төрийн мэдлийн компаниуд (Зэрэглэл: 38/45 оноо: 20/100)

Монгол улсын засгийн газар стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордуудыг эзэмшихэд төрийн ашиг сонирхлыг төлөөлөх зорилгоор Эрдэнэс МГЛ компанийг байгуулсан. Тус компанийн ямар үйл ажиллагаа явуулдаг талаар бараг ямар ч мэдээлэл байхгүй байна. Тус компани санхүүгийн тайлан мэдээлэлийг хэвлэж, нийтлэх хууль эрхзүйн үүрэг хүлээсэн хэдий ч , ямар ч санхүүгийн тайлан

мэдээлэлийг хэвлэдэггүй байна.

Дотоодын шилжүүлэг (Зэрэглэл: 19/30 оноо: 56/100)
Монгол улсын ашигт малтмалын хуулиар, роялти төлбөрийн 30 хувь болон тусгай зөвшөөрлийн төлбөр хураамжийн 50 хувийг орон нутгийн удирдлагад төлдөг. Байгалийн баялгийн

баялгийн орлогыг хуваалцах талаар журмыг ерөнхийдөө дагадаг төв засгийн зүгээс эдгээр шилжүүлгийн талаар хэвлэж, нийтэлдэг. Орон нутгийн удирдлага харин эдгээр шилжүүлгийг хүлээж авсан талаараа хэвлэж, нийтэлдэггүй.

Монголын нийт, бүрэлдэхүүн хэсгүүд болон индикатор үзүүлэлтийн оноонууд

Зэрэглэл (58 улсаас)		оноо (X/100)
26	Нийт оноо	51
9	Төрийн байгууллага, институцийн болон хууль эрхзүйн орчин	80
	Мэдээлэлийн эрх чөлөөний тухай хууль	67
	Салбарын талаарх цогц хууль журам	67
	Олборлох салбарын ил тод байдлын санаачилгад оролцож буй байдал	100
	Тусгай зөвшөөрлийг олгох үйл явц хараат бус эсэх	83
	Байгаль орчны болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаардлагатай	50
	Орлогыг цуглуулж байгаа үйл явц тодорхой байх	100
	Төрийн салбарын цогц, дэлгэрэнгүй баланс тайлан	50
	Төрийн мэдлийн компанийн санхүүгийн тайлан мэдээ шаардлагатай	100
	Сангийн журмыг хуулинд тусгасан	..
	Дотоодын санхүүжилтийн шилжүүлгийн журмыг хуулинд тусгасан	100
41	Тайлагнаж, мэдээлэх талаар	39
	Тусгай зөвшөөрлийг олгох үйл явц	67
	Гэрээ контракт	..
	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ	17
	Эрэл хайгуулийн өгөгдөл мэдээлэл	83
	Үйлдвэрлэлийн цар хэмжээ	67
	Үйлдвэрлэлийн цар хүрээ	56
	Орлогын үндсэн эх үүсвэрүүд	67
	Орлогын хоёрдагч эх үүсвэрүүд	50
	Татаас	33
	Үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нэр	67
	Төрийн мэдлийн компанийн цогц тайлан мэдээлэл	0
	Төрийн мэдлийн компанийн үйлдвэрлэлийн өгөгдөл мэдээлэл	0
	Төрийн мэдлийн компанийн орлогын өгөгдөл мэдээлэл	0
	Төрийн мэдлийн компанийн санхүүгийн үйл ажиллагаа	0
	Төрийн мэдлийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл	0
	Сангийн дүрэм	..
	Сангийн дэлгэрэнгүй тайлан	..
	Дотоодын шилжүүлгийн журам	100
37	Урьдчилан сэргийлэх болон чанарын хяналт	67
	Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг шалгах	0

	Төсвийн үйл явцыг шалгах	49
	Төр засгийн газрын тайлан мэдээний чанар	89
	Төр засгийн газрын ашиг сонирхлын зөрчлийг ил тод гаргасан байдал	78
	Төрийн мэдлийн компанийн тайлан мэдээний чанар	58
	Төрийн мэдлийн компанийн тайлан мэдээнд аудит хийсэн байдал	100
	Төрийн мэдлийн компани олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг ашигладаг эсэх	0
	Төрийн мэдлийн компани ашиг сонирхлын зөрчлийг ил тод гаргадаг эсэх	0
	Сангийн тайлан мэдээний чанар	0
	Сангийн тайлан мэдээнд аудит хийдэг эсэх	100
	Төр засгийн газар сангийн дүрмийг дагаж, мөрддөг эсэх	..
	Сангийн зарцуулалтын талаар шалгадаг эсэх	..
	Сан ашиг сонирхлын зөрчлийн талаар ил тод мэдээлдэг эсэх	..
	Дотоодын шилжүүлгийн талаар тайлан мэдээний чанар	..
	Дотоодын шилжүүлгийн дүрэм журмыг төр засгийн газар дагадаг эсэх	..
20	Орчин	0
	Авилгал (Транспэрэнси интернэшнл байгууллагын Авилгалын талаар ойлголтын индекс болон Дэлхийн засаглалын индикаторын авилгалын хяналт)	67
	Нээлттэй ил тод төсөв (Олон улсын Төсвийн түншлэл буюу IBP-ын индекс)	48
	Хариуцлагатай байдал болон ардчилал (EIU Ардчилалын индекс болон Дэлхийн засаглалын индексийн дуу хоолой болон хариуцлагатай байдлын үзүүлэлтээр)	31
	Төр засгийн үр дүнтэй байдал (Дэлхийн засаглалын индекс)	78
	Хуулийн засаглал (Дэлхийн засаглалын индекс)	56

- Хангалттай
- Бүрэн бус
- Сул
- Муу